



**ТЭЭВЭР ХӨГЖЛИЙН БАНКНЫ ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ХАРААТ БУС ГИШҮҮҮН Г.ЦОГТГЭРЭЛИЙН 2023 ОНЫ 3 ДУГААР УЛИРЛЫН
АЖЛЫН ТАЙЛАН**

2023 оны 10-р сарын 24

Улаанбаатар хот

Тээвэр хөгжлийн банкны Хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоолоор Г.Цогтгэрэл миний бие 2023 оны 1 дүгээр сарын 02-ны өдрөөс ТУЗ-ийн хараат бус гишүүнээр томилогдон ажиллаж байна. ТУЗ-ийн хараат бус гишүүний хувьд Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа “Компанийн тухай хууль”, “Банкны тухай хууль” болон Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар батлагдсан “Банкны зохистой засаглалын зарчмыг хэрэгжүүлэх журам”, “Банкны төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнийг нэр дэвшүүлэх, томилох, чөлөөлөх журам”, “Тээвэр хөгжлийн банкны Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам” зэргийг тус тус хэрэгжүүлэн ажилласан болно.

1. ТУЗ-ийн хуралд оролцсон байдал:

2023 оны 7 дүгээр сарын 01-ний өдрөөс 2023 оны 9 дугаар сарын 30-ны өдрийг хүртэлх хугацаанд Төлөөлөн удирдах зөвлөлийн нийт 3 хурал зарлагдснаас хараат бус гишүүний хувьд бүх хуралд 100% ирцтэйгээр асуудлуудыг хэлэлцэж, шийдвэрлэхэд саналын эрхтэй оролцсон байна. 2023 оны 08-р сарын 10-ны өдрийн хурлаар дараах асуудлыг хэлэлцэж, шийдвэрлэсэн. Үүнд:

1. Авлага эрсдэлийн сангаас хаах тухай асуудлыг хэлэлцэж шийдвэрлүүлэхээр Банкны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг 2023.08.25-ны өдрийн 15.00 цагт банкны хурлын танхимд хуралдуулахаар хурлыг товлов.
2. Банканд Privileged Access Management (PAM) системийг нэвтрүүлж ажиллахыг зөвшөөрөв.
3. Министер тауэр салбарыг нээхийг зөвшөөрч, холбогдох баримт бичгийг хууль журмын дагуу бүрдүүлж Монголбанканд хүргүүлэхийг Гүйцэтгэх удирдлагад үүрэг болгов.
4. Банкны бүтэц, орон тооны нэршилд өөрчлөлт оруулахаар шийдвэрлэж, хавсралтаар батлав.
5. Хөндлөнгийн Аудитын олон улсын байгууллага болох “BDO” ХХК-тай 2023 оны жилийн эцсийн санхүүгийн Аудитын үйлчилгээ үзүүлэх гэрээ байгуулах эрхийг Гүйцэтгэх захиралд олгов.
6. Банкны 2023 оны Үйл ажиллагаа, хөрөнгө оруулалтын зардлын төсвийг хавсралтаар шинэчлэн батлав.
7. Сингапур улсад ТХБанкны төлөөлөгчийн газар байгуулахыг зөвшөөрч, тус төлөөлөгчийн газрын удирдлагыг хэрэгжүүлэх эрх бүхий этгээдээр Хувийн банк хариуцсан захирал Энхбатын Мөнхжаргалыг томилов.

8. Гүйцэтгэх удирдлагын эхний хагас жилийн ажлын гүйцэтгэлийн тайлантай танилцав.

ТУЗ-ийн хурлаар дээрх асуудлуудыг хэлэлцэж шийдвэрлэхэд хараат бус гишүүний хувьд саналын зөрүүтэй зүйл байгаагүй. Банкны Хувьцаа эзэмшигч, ТУЗ ба гүйцэтгэх удирдлагын ил тод абдйл, шийдвэр гаргалт нь Компанийн тухай хууль, Банкны тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомж журмын дагуу байсан бөгөөд ТУЗ-аас гаргасан шийдвэр, тогтоолууд нь банкны харилцагч, хадгаламж эзэмшигчийн эрх ашигт сөргөөр нөлөөлөхөөргүй байсан болно.

2023 оны 09-р сарын 28-ны өдрийн хурлаар дараах асуудлыг хэлэлцэж, шийдвэрлэсэн. Үүнд:

1.Мөн банкны нэр дээрх хөрөнгүүдийг акталж, балансаас хасах тухай асуудлыг Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар хэлэлцүүлж холбогдох шийдвэрийг гаргуулахаар шийдвэрлэв.

2.Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга П.Даваа болон ТУЗ-ийн гишүүн З.Мөнхзаяа нар чөлөөлөгдөж байгаатай холбоотой Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг яаралтай 2023 оны 09 дүгээр сарын 29-ний өдрийн өглөө 11.00 цагт банкны хурлын танхимд зарлан хуралдуулахаар шийдвэрлэв.

3.Батчулуун овогтой Эрдэнэбаяр /РД: ТБ87030671/-г 2023 оны 10 дугаар сарын 02–ны өдрөөс эхлэн Тээвэр хөгжлийн банкны Төлөөлөн удирдах зөвлөлийн даргаар томилж, Төлөөлөн удирдах зөвлөлийн даргын ажлыг 2023 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор хүлээлцэхийг доорх бүрэлдэхүүнтэй ажлын хэсэгт даалгаж:

Ажлын хэсгийн ахлагч: Х.Баттулга /Дотоод Аудитын газрын захирал/

Гишүүд: С.Сайнжаргал /ТУЗ-ийн нарийн бичгийн дарга/

Ц.Бат-Идэр /Үйл ажиллагаа хариуцсан захирал/

Ц.Болор /Санхүү хариуцсан захирал/

4.“Зээлдэгч Д.Цогтэрэлийн зээлийн үлдэгдлийг 2023 оны 09 дүгээр сарын 28-ны өдрөөр дуусгавар болгон хааж, барьцаа хөрөнгө болох Caterpillar загварын 3 ширхэг экскаватор, 4 ширхэг өөрөө буулагч, 3 ширхэг авто ачигч, 1 ширхэг автогрейдэр буюу нийт 11 ширхэг машин механизмыг банкны ӨБХХ- “Бусад хөрөнгө” дансанд бүртгэхийг зөвшөөрөв. Банкны Нягтлан бодох бүртгэлийн заавар, СТОУС-ын дагуу холбогдох тооцооллыг нарийвчлан гаргаж зөрүү төлбөр үүссэн тохиолдолд зээлдэгчээр төлүүлэх, гэрээ байгуулах арга хэмжээ авч ажиллахыг Гүйцэтгэх удирдлага, Зээл хариуцсан нэгж, Зээлийн Ерөнхий хороонд тус тус үүрэг болгохоор шийдвэрлэв. ӨБХХ-д бүртгэснээс хойш 1 сарын дотор зориулалтыг тодорхой болгож, зохих дансанд шилжүүлэн бүртгэх эрхийг Гүйцэтгэх захирал /Б.Энэрэлт/-д олгохоор шийдвэрлэв.

ТУЗ-ийн хурлаар дээрх асуудлуудыг хэлэлцэж шийдвэрлэхэд хараат бус гишүүний хувьд 4 дэх асуудалд түтгэлзсэн санал өгсөн. Банкны Хувьцаа эзэмшигч, ТУЗ ба гүйцэтгэх удирдлагын ил тод

абдйл, шийдвэр гаргалт нь Компанийн тухай хууль, Банкны тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомж журмын дагуу байсан бөгөөд ТУЗ-аас гаргасан шийдвэр, тогтоолууд нь банкны харилцагч, хадгаламж эзэмшигчийн эрх ашигт сөргөөр нөлөөлөхөөргүй байсан болно.

2. Аудитын хороонд ажилласан тухай:

Аудитийн хороо нь 2023 оны 3-р улиралд 1 удаа буюу 2023 оны 08 дүгээр сарын 10-ны өдөр хуралдаж дараах асуудлыг хэлэлцсэн. Үүнд:

1. Дотоод Аудитын газрын 2023 оны эхний хагас жилийн ажлын тайлангийн тухай
2. Дотоод Аудитын газраас Премиум салбарын харилцагчийн үйлчилгээний ахлах ажилтан Л.Батбаатарын ашиглангийн үйлдэл шалгасан тайлангийн тухай
3. Дотоод Аудитын газраас МАБХ-ийн үйл ажиллагаанд хийсэн аудитын тайлангийн тухай

Аудитын хорооны хурлаас дараах санал дүгнэлтийг гаргасан болно. Үүнд:

1. Дотоод Аудитын газраас Гүйцэтгэх удирдлага, МАБХ-т өгсөн хугацаатай үүрэг даалгаварыг бүрэн хэрэгжүүлж биелэлтийн тайланг 2023 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ТУЗ-ийн Аудитын хороонд танилцуулахыг Дотоод Аудитын газарт үүрэг болгов;
2. Аудитын хорооны гишүүдэд явуулдаг сар бүрийн тайландаа Монголбанкнаас өгсөн үүрэг даалгаварын биелэлтийн байдлыг тусган танилцуулж байхыг Дотоод Аудитын газарт үүрэг болгов;
3. Банканд шинээр ажилд авч буй ажилчдаас зээлийн мэдээллийн сангийн лавлагаа болон И-монголиа сангаас ёргууль төгссөн мэдээлэл зэргийг авдаг болох мөн бусад шаардлагатай баримт бичгийн бүрдлийг хангаж ажиллахыг Хүний нөөцийн газарт;
4. Үүсч бий болох аливаа нэгэн үйл ажиллагааны эрсдлээс урьдчилан сэргийлж ажиллахыг Эрсдэлийн удирдлагын газарт;
5. Салбаруудад давхар хяналтыг сайжруулж, дахин ашиглангийн хэрэг гаргахгүй байхад анхаарч урьдчилан сэргийлж ажиллахыг Салбарын удирдлагын газарт;
6. Банканд мөрдөгдөж буй бүхий л дүрэм, журам, заавруудыг дахин хянаж нягтлах, шаардлагатай засварыг оруулах, тэдгээрийн хэрэгжилтэд хяналт тавьж, банкны ажилчдад журам, зааврын хэрэгжилтийн талаар тогтмол сургалт орж ажиллахыг Хууль эрх зүйн газар болон Хүний нөөцийн газарт тус тус үүрэг болгож байна;
7. Банканд аливаа аж ахуйн нэгж, байгууллагаас ирж буй хугацаатай албан бичгүүдийн бүртгэлийг цаг тухайд нь хийж, тус албан бичгүүдэд эргэн хяналт тавьж ажиллахыг Гүйцэтгэх захирлын ажлын албанд тус тус үүрэг болгож байна;
8. Тус хурлаас гарсан санал дүгнэлтийг Гүйцэтгэх удирдлагад хүргүүлж хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга /С.Сайнжаргал/-д үүрэг болгов.

3. Эрсдэлийн удирдлагын хороонд ажилласан тухай:

Эрсдэлийн удирдлагын хороо тайлант хугацаанд 1 удаа буюу 2023 оны 09 дүгээр сарын 01-ны өдөр хуралдаж дараах асуудлыг хэлэлцсэн. Үүнд:

1. Үндсэн хөрөнгийг данснаас хасах тухай
2. Эрсдэлийн нэгдсэн тайлан 2023 оны 7 дугаар сарын байдлаар танилцуулах тухай
3. ICAAP, ILAAP-г дотооддоо үнэлэх аргачлалын тухай
4. Эрсдэлийн нэгжүүдийн ажлын тайланг танилцуулах тухай

Эрсдэлийн хорооны хурлаар дараах санал дүгнэлтийг гаргасан болно.

1. Өмнөх хороодын хурлуудаар өгсөн үүрэг даалгаварын биелэлтийг дараагийн хуралд заавал танилцуулдаг байх;
2. Төлбөр тооцоо, бүртгэлийн газарт үүрэг болгох нь: Данснаас хасах банкны нэр дээрх зарим бараа бүтээгдэхүүнийг түрээслэх асуудлыг хэрэгжүүлж ажиллах талаас нь судалгаа хийх; Эд хөрөнгийн тооллого явуулах журмын процессийн хяналтыг сайжруулах үүднээс дахин шинэчилж батлах;
3. Үйл ажиллагааны газарт: Банкны нийт газар нэгж тус бүрийг өөрсдийн хөрөнгийн бүртгэлийг эзэнжүүлэн хөрөнгө тус бүрийн бүртгэл хөтлөлт хийх ажлыг зохион байгуулж ажиллах; хөрөнгийн элэгдэл, үнэ цэнийн хүрээнд бараа бүтээгдэхүүн, хөрөнгийг түрээслэх талаарх ажлыг судалгаа хийж, бусад банкуудаас туршлага судлахыг;
4. Тайлагналтай холбоотой хөгжүүлэлтийн тогтолцоог бий болгон 2023 онд багтааж нэвтрүүлж ажиллахыг, нэн шаардлагатай хүний нөөцийг гүйцэтгэх удирдлагын баг зохион байгуулж ажиллахыг.
5. Эрсдэлийг бууруулах үүднээс ямар арга хэмжээ авч ажилласан мөн ямар үр дүнд хүрсэн талаарх мэдээллийг эрсдэлийн тайланд тусгадаг байхад анхаарч ажиллах;
6. Тус хурлаас гарсан үүрэг даалгаварын биелэлтийн байдалд хяналт тавьж ажиллахыг хорооны нарийн бичгийн даргад үүрэг болгов. ТУЗ-ийн хараат бус гишүүний хувьд эрсдэлийн хорооны хурлаас гаргасан дүгнэлтэй саналын зөрүүтэй зүйл байгаагүй. Эрсдэлийн хорооны хурлаас гарсан санал, дүгнэлт, зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллахыг Гүйцэтгэх удирдлагад үүрэг болгов.

Тайлан бичсэн:

ТУЗ-ийн хараат бус гишүүн ...



/Г.Цогтгэрэл/